БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

...../Ч.ТӨГСДЭЛГЭР /

СТА5795
9077243

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 13 ДУГААР ХОРОО, ЭМЭЭЛТ ЭКО АЖ ҮЙЛДВЭРИЙН ПАРКИЙН УНД АХУЙН УС ХАНГАМЖИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Дугаар МЗХ 2025/00-129 Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Монгол улсын Их Хурлын 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага - Монгол Улсын Их хурлын 2020 оны 5 сарын 13-ний өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа- 2050" монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичиг - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл; - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр; - Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.3 дахь заалт; - Засгийн газрын 2023 оны "Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 193 дугаар тогтоол; - Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн 94 дүгээр тогтоол Эмээлт үйлдвэр технологийн парк ХХК ны техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай; - Монголын мянганы сорилтын сан УТҮГ-ын 2022 оны 05 дугаар сарын 25 ны өдрийн 03/146 тоот албан бичиг - Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 4 дүгээр хурлын шийдвэр
2.	Зураг төсөл боловсруулах үе шат хугацаа	- Бэлтгэл ажил (инженер геологийн дүгнэлт, дэвсгэр зургийн тодруулга) - Шинээр барих ундны усны усан сан, насос станц, дамжуулах шугам сүлжээ
3.	Байршил, газар эдэлбэрийн одоогийн байдал	- Хан-Уул дүүрэг, 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах "Эмээлт эко аж үйлдвэрийн парк"-ийн 160 га талбай.
4.	Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	**Монгол Улсын хуулиуд**: - Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; - Барилгын тухай Монгол Улсын хууль; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Усны тухай хууль;

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР

ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА

2025 оны 01 -р сарын 30 өдөр

		- Инженерийн шугам сүлжээний ажлын зургийг UTM-координатын системд хийж гүйцэтгэн батлагдсан ажлын зургийг CD-ээр Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэст хүлээлгэн өгөх - Ажлын зурагт бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийг нэг дэвсгэр дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөж, шугам сүлжээний ашиглалтын байгууллагуудтай зөвшилцсөн байх шаардлагатай.
7.	Инженерийн хангамжийн байгууламжийн үндсэн хийц	**Усан сан:** - Унд ахуйн усны шугам сүлжээний тохируулах усан сан, насос станцын барилгын байршил тогтоож баталгаажуулах - Эх үүсвэрээс хангагдаж байгаа хэрэглэгчдийн хэрэглээний нэгдсэн тооцоолол хийх , шугам сүлжээний төлөвлөлт нэгтгэж оруулах **Унд ахуйн усны шугам сүлжээ:** - Доод эх үүсвэрийн цэвэршүүлсэн усны ф700 мм ийн дамжуулах шугамнаас шинээр дамжуулах шугам татаж холбох - Төлөвлөлтийн барилга байгууламжийн ус хангамжийн шугам сүлжээг хэрэглээнээс хамаарч тусад нь төлөвлөх - Төлөвлөж буй шугам хоолой нь HDPE100 маркийн материалтай, ханын зузаан SDR17-оос багагүй байх. - Төлөвлөж буй хаалт арматур нь PN 10 ата даралт даах чадвартай байх. - Ус хангамжийн шугам сүлжээний угаалга , шахалт, туршилт тохируулгын ажлын зардлыг зураг төсөвт тусгах
8.	Шугам сүлжээний трасс сонголтонд тавигдах шаардлага	- Авто зам, төмөр зам, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тогтоох - Бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөсөн ажлын зурагтай уялдуулах - Трассанд өртөж байгаа нэгж талбаруудыг зурагт тэмдэглэж газар чөлөөлөлтийн зардал тооцон төсөвт тусгах, холбогдох байгууллагуудтай зөвшилцөх - Шаадлагатай тохиолдолд хонгилын систем төлөвлөх
9.	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Төсвийг ESTIMATOR -PRO программ болон түүнтэй ижил цалинг дундаж зэргээр тооцдог зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад програмаар тооцно.
10.	Зураг төсөл боловсруулах хугацаа	- Гэрээнд заасан хугацаагаар
11.	Зураг төсөл боловсруулах байгууллага	- Зөвлөх үйлчилгээний **ЗТ-3.4, 4.4, 5.4, 10.2** заалттай эрх бүхий хуулийн этгээд
12.	Галын аюулгүй байдлын нөхцөл	- Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал БНбД 21.01.02 - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм БНбД 21.02.02

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2021 оны 01 -р сарын 30 өдөр
СБТА 24956 2117401

		- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль ; - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Хот суурин газрыг дахин хөгжүүлэх хууль; - Бусад холбогдох хууль тогтоомжууд **Норм, нормативууд**: - Усан хангамж, гадна сүлжээ ба байгууламж /БНбД 40-02-16/ - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт БНбД 30-01-04 - Усан хангамж, ариутгах татуургын сүлжээний хуванцар хоолойг төлөвлөх ба угсрах. Үндсэн журам БД 40-102-06 - Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа /БД 11-102-07/ - Захиалагчийн дүрэм УББ12-201-01 - Тоног төхөөрөмж ба дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт БНбД 41-04-13 - Барилгын орчны тохижилтын ажил БНбД 3.01.06-90 - Цутгамал бетон, төмөр бетон бүтээц БНбД 3.03.01-88 - Угсармал төмөр бетон бүтээц БНбД 3.03.02-90 - Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм БНбД 11-04-99 - Барилга байгууламжийн галын аюулгүй байдал БНбД 20-01-02 - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх болон бусад БНбД, БД, холбогдох стандартуудыг мөрдлөгө болгох **Холбогдох журмууд**: - Монгол улсын Засгийн газрын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолоор батлсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах магадлал хийх дүрэм" - Бусад холбогдох журмууд
5.	Хэрэглэгчийн ачаалал	- Баруун доод эх үүсвэрийн цэвэршүүлсэн усны шугамнаас хангагдах бүсийн хэрэглээ: 5300 м3/хон - Ундны усны хэрэглээ: 1600 м3/хон
6.	Ажлын зураг төслийн бүрдэл	**Иж бүрдэл:** - Бэлтгэл ажил (инженер геологийн дүгнэлт, дэвсгэр зургийн тодруулга, шугам сүлжээний трассын дагуух өндөржилтийн зураг М1:500) - Ундны усны усан сан, насос станц, дамжуулах шугам сүлжээний ажлын зураг төсөв - Төлөвлөж буй үйлдвэрүүдийн ундны усны цагираг шугам, барилга хоорондын салбар шугамын ажлын зураг төсөв. **Зураг төсөлд тавигдах шаардлага:** - Зураг төслийн баримт бичиг 4 хувь. Үүнээс: график зураглал CD-ний хамт 2 хувийг захиалагчид, үндсэн хувийг архивт өгнө.

ХОТ БАЙГУУЛАЛТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2025 оны 01 -р сарын 30 өдөр
СБТ№ 24056 2117401

13.	Зураг төслийн санхүүжилт	- Нийслэлийн төсвийн хөрөнгөөр
14.	Төслийн захиалагч	- "Эмээлт эко аж үйлдвэрийн парк" ХК, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
15.	Байгаль орчны үнэлгээ нөхцөл	- Шаардлагатай тохиолдолд байгаль орчны үнэлгээ хийлгэх
16.	Онцгой нөхцөл (Төлөвлөлтийн шаардлагаар гарах нэмэлт шаардлагууд трассын дагуух газар чөлөөлөх, хөрсний шинж чанараас хамаарсан нэмэлт төлөвлөлт, шинэ техник технологи хэрэглэх гэх мэт)	- Төлөвлөж буй эх үүсвэр, ус хангамжийн шугам сүлжээнд одоо болон хэтийн төлөвлөлтөөр холбох хэрэглэгчдийн ачааллыг тусгасан байх /Аргалант-Эмээлт, 361 гарам/ - Батлагдсан зураг төслийн дагуу барилга угсралтын ажил гүйцэтгэх; - Ус хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг батлагдсан норм дүрмийн дагуу тооцож төлөвлөх - Батлагдсан техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөлтэй уялдуулах - Шугам сүлжээний системийн угаалга, шахалт, туршилт тохируулгын ажлын зардлыг зураг төсөвт тусгах - Инженер геологийн судалгаанд үндэслэн шугам сүлжээний трассын дагууд хөрсний ус зайлуулах шүүрүүлийн байгууламж төлөвлөх, шугамын материалыг PE өндөр даралтын цэвэр усны хоолой MNS ISO 4427:2007 стандарт болон бусад стандартын шаардлага хангасан байхаар тооцох. - Ажлын зураг төсөлд авто зам, ногоон байгууламж, тохижилтын ажлыг нөхөн сэргээх зардлыг холбогдох дүрэм журам, үнэлгээний дагуу тооцон төсөвт тусгах

26 01-р сарын 30

ХЯНАСАН:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР, ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Б.ОЮУНТУЯА

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГ-ЫН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР — Ж.ДАГВАСҮРЭН

ЭМЭЭЛТ ЭКО АЖ ҮЙЛДВЭРИЙН ПАРК ХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ — Б.МЯГМАР

БОЛОВСРУУЛСАН:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР, ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН — Б.ЦЭРЭННАДМИД

МОНГОЛЫН МЯНГАНЫ
СОРИЛТЫН САН
МПМ Цогцолбор, 5-р давхар, ЮНЕСКО -ийн гудамж,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс.
Утас: +976 7711 1710, Э-шуудан: info@mca-mongolia.gov.mn
Вэб хуудас: www.mca-mongolia.gov.mn

2022. 05. 25 № 03/146

танай _____-ны №_____-т

ЭМЭЭЛТИЙН ЭКО АЖ
ҮЙЛДВЭРИЙН ПАРК НӨААТҮГ-ИЙН
ЗАХИРАЛ Б.МЯГМАР ТАНАА

Хамтран ажиллах тухай

Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын хооронд Мянганы сорилтын Компакт гэрээг 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр байгуулж, Улсын Их Хурлаар 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр соёрхон батлсан.

Компакт гэрээний хүрээнд Улаанбаатар хотын нийт ус хангамжийг урт хугацаанд, тогтвортой нэмэгдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 350 сая ам.долларын буцалтгүй тусламжийг үзүүлэх юм.

Монгол Улсын Засгийн газрын эрх, үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхээр "Монголын Мянганы сорилтын сан" ҮТҮГ-ыг байгуулсан ба дээр дурдсан Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгүүлэх хөтөлбөрийн хүрээнд (i) Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл, (ii) Хаягдал ус дахин боловсруулах төсөл, (iii) Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл гэсэн харилцан уялдаа бүхий төслүүдийг хэрэгжүүлнэ.

Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн хүрээнд Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн шинэ эх үүсвэрүүд байгуулж, хоногт 140 мянган шоо метр хүртэл, жилд 50 сая шоо метр хүртэл усыг ундны усны стандартад нийцүүлэн цэвэршүүлж, нийслэлийн ус хангамжийн төвлөрсөн сүлжээнд нийлүүлнэ.

Баруун эх үүсвэрийн төслийн үндсэн дэд бүтэц болох эх үүсвэрийн барилга байгууламж, ус гүн цэвэршүүлэх үйлдвэр, түүхий болон цэвэршүүлсэн ус дамжуулах шугам хоолойн нарийвчилсан зураг төслийг 2019 оны 4 дүгээр сараас эхлэн боловсруулж, 2021 онд ажлын зураг, төсөвт магадлал хийгдэж баталгаажсан.

Энэхүү зураг төсөлд Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрт цэвэршүүлсэн усыг хотын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх шугамын дагууд Улаанбаатар хотын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ус хэрэгцээний тооцоотой уялдуулан ирээдүйн хэрэглэгчдийг холбох боломжийг бүрдүүлэх зорилгоор зургаан (6) гаргалгааны цэгтэй байхаар төлөвлөсөн. Үүнд: 1) Био, Өлзийт, Аэросити, Майдар

хот - 712 м3/ц; 2) Жаргалант, **Эмээлт**, Аргалант, Рашаант - 346 м3/ц; 3) Агропарк, Тахилт, Шинэ хотын төв - 661 м3/ц; 4) Орбит, Баянгол, Толгойт - 1335 м3/ц; 5) Ирээдүйн үйлдвэрлэлийн бүсийн холболт– 1000 м3/ц.; 6) Баруун бүсийн бусад хэрэглээ – 742 м3/ц тус тус багтсан.

Эмээлтийн Эко Аж Үйлдвэрийн Парк НӨААТҮГ нь Баруун эх үүсвэрийн төслийн төлөвлөлтийн хүрээнд цэвэршүүлсэн усны шугамын дагуух дээрх холболтын цэгээс тооцоологдсон ундны болон технологийн ус хангамжийг хэрэгцээг шийдвэрлэх бүрэн боломжтой болохыг мэдэгдэхэд таатай байна. Иймд тус паркийн ус хангамжийн төлөвлөлт, зураг төслийг Баруун эх үүсвэрийн төслийн төлөвлөлттэй уялдуулан төлөвлөж, гүйцэтгэх шаардлагатай гэж үзэж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.УРАНЧИМЭГ

УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН ҮТҮГ
АТА2724 6299331
1119276496

ШИЙДВЭР: СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 24-НЫ ӨДРИЙН 94 ДУГААР ТОГТООЛООР ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАГДСАН

ЗАХИАЛАГЧ: ЭМЭЭЛТ ЭКО АЖ ҮЙЛДВЭРИЙН ПАРК

БАЙРШИЛ : ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 13 ДУГААР ХОРОО



ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАРТ

"ЭМЭЭЛТ ЭКО АЖ ҮЙЛДВЭРИЙН ПАРК" ХК

Нийслэлийн Засаг захиргааны II байр, Цэргийн дурсгалт Гудамж, 1 дугаар хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976) 7010 0711, Факс: (976) 7711 7011
Цахим шуудан: info@emeeltpark.mn
Цахим хуудас: www.emeeltpark.mn

Зургийн даалгавар боловсруулах тухай

Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын болон Нийслэлийн засаг дарын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд Эмээлт эко аж үйлдвэрийн парк" (ЭЭАҮП)-г байгуулах, паркийн дэд бүтцийг хөгжүүлэх тухай зорилтууд тусгагдан, хууль эрх зүйн орчин бүрдсэн.

"Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл" олгогдож, ЭЭАҮП-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон Техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-г Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн 2024 оны 7 сарын 24-ний өдрийн 94 дугаар тогтоолоор батлуулсан.

Дээрх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тус паркад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, ноос боловсруулах үйлдвэрүүдээс болон ахуйн хэрэглээнээс